

**“МОНГОЛ КООСЭН” ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН
ОЮУТНЫ ДОТУУР БАЙРНЫ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь “Монгол Коосэн” Технологийн коллежид /цаашид МКТК гэнэ/ суралцаж буй оюутны дотуур байранд амьдрахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Дотуур байранд амьдрах хүсэлт гаргах, байрлуулах

- 2.1. Хүсэлт гаргагч нь МКТК-ийн суралцагч байх бөгөөд дотуур байранд амьдрах хүсэлт гаргах, хүсэлтийг баталгаажуулах үйл ажиллагааг Оюутны алба хариуцан ажиллана.
- 2.2. Байранд амьдрах хүсэлтийг 8-р сарын 10-ны өдрөөс эхлэн 8-р сарын 25-ны өдрийг хүртэл хүлээн авах ба хүсэлт гаргагч нь өрөөг сонгож болно.
- 2.3. Эрэгтэй, эмэгтэй оюутан нэг өрөөнд байрлахгүй.
- 2.4. Байрны хуваарилалт хийсний дараа МКТК-ийн Оюутны алба, ангийн зөвлөх багш, оюутан болон оюутны эцэг, эх, асран хамгаалагчтай гэрээ байгуулна.
- 2.5. Байранд амьдрах эрх авсан бүх оюутан хичээлийн бүтэн жилээр гэрээ байгуулна. Гэрээ байгуулахдаа дараах материалыг бүрдүүлж Оюутны албанд өгнө. Үүнд:
 - a) Хүсэлт гаргагчийн маягт /Оюутны албанаас авах/
 - b) Байрны төлбөр төлсөн баримт /жилээр/
 - c) Эрүүл мэндийн даатгал төлсөн баримт
 - d) Эрүүл мэндийн үзлэгийн хуудас
- 2.6. Гэрээний нэг хувийг Оюутны алба хадгалж, нэг хувийг оюутанд олгоно.
- 2.7. Оюутны алба өрөөг хүлээлгэж өгөхдөө байрны эд хогшил, тавилга, тоног төхөөрөмжийг бүртгэлийн картанд тусган түлхүүрийн хамт олгоно.
- 2.8. Хичээлийн жилийн явцад оюутан өөрийн хүсэлтээр хүндэтгэх шалтгааны улмаас дотуур байрнаас гарах тохиолдолд 7 хоногийн өмнө хүсэлтээ Оюутны албанд өгөх бөгөөд холбогдох тооцоог дуусгаснаар байрнаас гарна.
- 2.9. Байрлах хугацаа гэрээний хугацаанаас хэтэрсэн тохиолдолд тухайн хэтэрсэн хугацааны мөнгийг тооцож сургуульд тушаана.
- 2.10. Гэрээний хугацаа дууссан, хугацаанаас өмнө гарах оюутан нь өрөөг цэвэрлэн, эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг Оюутны албанд бүрэн хүлээлгэж өгнө.

- 2.11. Оюутан дотуур байрнаас гарахдаа өөрийн эд зүйлсээ бүрэн авч гарна.
- 2.12. Оюутны амьдарч байсан өрөөний эд хогшил, тоног төхөөрөмж эвдэрсэн, алга болсон тохиолдолд хохирлыг барагдуулна. Тогтоосон хугацаанд хохирлыг барагдуулаагүй тохиолдолд оюутны сургалтын болон оюутанд үзүүлэх үйлчилгээг хязгаарлана.

Гурав. Байрны удирдлага

- 3.1. Оюутныг байраар хангах, тэдэнд соёл хүмүүжил, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг үзүүлэх ажлыг Оюутны алба хариуцан ажиллана.
- 3.2. Оюутны байрны зөвлөл, үүрэг
 - 3.2.1. Байрны зөвлөл 5 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд зөвлөлийн дарга, гишүүдийг байранд амьдарч байгаа оюутны хамт олны хурлаас нэр дэвшүүлэн нэг жилийн хугацаатайгаар сонгоно. Дарга, гишүүдийг сонгохдоо өмнө нь оюутны байранд амьдрах хугацаандаа ямар нэгэн зөрчил гаргаж байгаагүй оюутнуудаас сонгоно.
 - 3.2.2. Байрны зөвлөл нь байрны удирдлагыг хэрэгжүүлэхэд холбогдох нэгж болон албан тушаалтанд дэмжлэг үзүүлж ажиллана.
 - 3.2.3. Оюутны байранд амьдарч буй оюутны эрхийг хамгаалах, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх талаар үйл ажиллагаа зохион байгуулж хууль тогтоомж, дэг журмыг сахиулна.
 - 3.2.4. Байранд тохь тухтай амьдрах нөхцөлийг хангахад чиглэсэн аливаа арга хэмжээ санаачлан, зохион байгуулж, оршин суугчдын оролцоог хангана.
 - 3.2.5. Оюутны дунд соёлтой, зөв боловсон амьдрах хэв журмыг сурталчлах, сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг санаачлан зохион байгуулна.
 - 3.2.6. Оюутны байрны зөвлөл нь хичээлийн жилийн эцэст үйл ажиллагааны тайлангаа Оюутны албанд хянуулж, ажлаа дүгнүүлнэ.

Дөрөв. Байрны дэг журам

- 4.1. Оюутан байрны журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, байрны зохион байгуулагч, ажилчин болон бусад оршин суугчтай нийцтэй, зөв боловсон харьцаж аж төрнө.
- 4.2. Оюутан амьдарч буй өрөөний ариун цэвэр, аюулгүй байдал, эд хогшлын бүрэн бүтэн байдлыг хариуцна.
- 4.3. Оюутны дотуур байрны урсгал засвар, хортон шавьжийн устгал, ариутгал хийх нөхцөлд өрөөг тухай бүрт нь саадгүй чөлөөлж, бэлэн байлгана.
- 4.4. Өрөөгөө эзгүй орхихдоо гал, ус, цахилгааны аюулгүй байдлыг хангана.

- 4.5. Оюутан нь байранд дараах үйлдэл гаргахыг хориглоно. Үүнд:
- 4.5.1. Согтууруулах ундаа хэрэглэх, тамхи татах, мансууруулах үйлчилгээтэй бодис хэрэглэх, хадгалах,
 - 4.5.2. Оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах аливаа үйлдэл;
 - 4.5.3. Өрөөний зохион байгуулалт өөрчлөх, өрөөгөө зөвшөөрөлгүй солих, өрөөний эд хогшлыг зориулалтын бусаар ашиглах, гадагш гаргах, зөөж оруулах, бусадтай солилцох;
 - 4.5.4. Дур мэдэн цахилгааны холбоог өөрчлөх;
 - 4.5.5. Амралтын цагаар байраар сэлгүүцэх, хөгжим, телевизийн дууг чангалах;
 - 4.5.6. Тэсэрч дэлбэрэх болон химийн хортой бодис оруулах, хадгалах;
 - 4.5.7. Худалдаа үйлчилгээ явуулах;
 - 4.5.8. Бусдыг өөрийн нэрээр оруулах, байранд нэвтрэх үнэмлэхийг бусдад шилжүүлэх;
 - 4.5.9. Байранд нохой, муур болон бусад амьтан тэжээх;
 - 4.5.10. Улс төр, шашны суртал ухуулга хийх;
 - 4.5.11. Гаднаас зочид гийчид буюу эцэг эх, ах дүү, найз нөхдийг байрны өрөөнд оруулах, хонуулах;
 - 4.5.12. Бусдыг эд зүйлийг зөвшөөрөлгүй авах;
 - 4.5.13. Сургуулиас олгосон эд зүйлийг гамгүй хэрэглэх, эвдлэн сүйтгэх;
 - 4.5.14. Нийгмийн хэв журам зөрчих, Монгол улсын хууль, МКТК-ийн дүрэм, журмаар хориглосон бусад үйлдэл хийх;
- 4.6. Оюутан дотуур байрандаа оройн 22:00 цагаас өмнө ирсэн байх шаардлагатай. Хэрэв 22.00 цагаас хэтэрсэн бол дотуур байранд оруулахгүй.
- 4.6.1. Оюутан өвдсөн бол Оюутны албанд даруй мэдэгдэнэ.
 - 4.6.2. Өөрийн хувийн эд зүйлээ оюутан өөрөө хариуцна.
 - 4.6.3. Хэрэв цагийн ажил хийж байгаа бол Оюутны албанд заавал мэдэгдэнэ.
 - 4.6.4. Хичээлийн болон амралтын өдөр гадуур хонох бол 2 өдрийн өмнө Оюутны албанд мэдэгдэж, маягт бөглөн зөвшөөрөл авна. Хэрэв мэдэгдээгүйн улмаас ямар нэг зөрчил гаргасан тохиолдолд сургууль хариуцлага хүлээхгүй.
 - 4.6.5. Дотуур байрны гал тогоо, угаалгын газрыг цэвэр нямбай ашиглана.
 - 4.6.6. Оюутан өөрийн оршин суугаа өрөөндөө хоол хийхгүй, хөргөгч, плитка, халаагуур болон ус буцалгагч байрлуулахгүй. Зөвхөн сургуулиас заасан зориулалтын газар байрлуулан ашиглана.

Тав. Бусад

- 5.1. Байрны дэг журам зөрчсөн тохиолдолд байрны зөвлөл, Оюутны алба болон холбогдох бусад удирдлагын санал, дүгнэлтийг үндэслэн байрнаас гаргах хүртэл арга хэмжээ авна.
- 5.2. Энэ журмын 4 дэх хэсэгт заасан журмыг зөрчсөн оршин суугчийн төлбөрийг буцаан олгохгүй.
- 5.3. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал үүссэн тохиолдолд Оюутны алба, бусад алба нэгж хамтран МКТК-ийн дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэнэ.

-00o00-

Хичээлийн болон амралтын өдөр гадуур хонох тухай зөвшөөрөл хүссэн маягт

Хавсралт 2.

Оюутны байрны өмчийн жагсаалт